



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/425

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.4, 4.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит 18 дугаар хурлын 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн дээд шагналаар шагнагдсан хүмүүст хүндэтгэл үзүүлэх журам", аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны XVI дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ази тивийн аварга шалгаруулах бодибилдинг фитнесийн тэмцээнд оролцох Даваажаргал овогтой Лхагва-Очирт дэмжлэг үзүүлж 2,000,000 (хоёр сая) төгрөг, 21 аймгийн насанд хүрэгчдийн хөл бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох шигшээ багийн тамирчдад дэмжлэг үзүүлж Хөвсгөл аймгийн хөл бөмбөгийн холбоонд 500,000 (таван зуун мянган) төгрөг, үйлчилгээний гавьяат ажилтан цол тэмдгээр шагнагдсан Цэдэвийн Хөвсгөлдалайд, Монгол улсын Хүний гавьяат эмч цол тэмдэгээр шагнагдсан Лхамсүрэнгийн Гэрэлхүүд тус тус 2,000,000 (хоёр сая) төгрөгийг шийдвэрлэж зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 6,500,000 (зургаан сая таван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



671 0010043